ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД,ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЭТЧМИХАМЭРГЭЖИЛТЭН П.ХИШГЭЭ

**1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ дараахь төрөлтэй байна:**

1.Өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний анхан шатны тусламж, үйлчилгээг бие дааж, эсхүл багаар үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

2.Өрхийн анагаах ухаанаас бусад мэргэшлийн эмнэлгийн мэргэжилтний бие дааж, эсхүл багаар үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;

3.Жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;

4.Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;

5.Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

6.Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжих, хөнгөвчлөх, илааршуулахад чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;

7.Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ.

V

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

# СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

# ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд 2021-2023 он Орхон аймаг




Амьсгалын тогтолцооны өвчин 310.4, хоол боловсруулах тогтолцооны өвчин 66.9 промилоор буурч, шээс бэлгийн тогтолцооны өвчин 10.1, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 116.6, гэмтэл хордлого бэртэл гадны шалтгаант өвчлөл 7 промиллоор өссөн байна.

# ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Орхон аймгийн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан /10000 хүн амд /2015-2023 он




- ✓ Аймгийн хэмжээнд нас баралтын 439 тохиолдол бүртгэгдэж 1000 хүн амд 4.1 промил.
- ✓ Нийт нас баралтын 42.6 %-ийг зүрх судасны нас баралт 25.9%-ийг хорт хавдар, 9.6 %-ийг осол гэмтэл гадны шалтгаант нас баралтууд эзэлж байна

# ОРХОН АЙМГИЙН ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ 2022

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ




| Орхон | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дундаж наслалт | 71.07 | 71.33 | 71.91 | 72.15 | 72.34 | 72.6 | 73.6 |
| Жилийн өсөлт | -0.31 | 0.26 | 0.58 | 0.24 | 0.19 | 0.26 | 1 |

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХҮРЭХ 17 ЗОРИЛГО 2016-2030

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

Дунд зэрэг

!!! Хүйсийн насны зөрүү 12

72.2 84.4

# ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ



# ТАВ ХҮРТЭЛ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ








# ТАВ ХҮРТЭЛ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2024 ОРХОН АЙМАГ



# ЖИРЭМСЭН, ТӨРӨХ ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

## Төрөлт –Орхон аймаг




## Жирэмсний хяналт /Орхон аймаг/




**Жирэмсэн, төрөх , төрсний дараахь үеийн тусламж үйлчилгээг анхан болон 2 дахь шатлалын 9 байгууллага үзүүлж байна.**

1.Жирэмсний хяналт:

- Эрт үеийн хяналт **98,5% ,** жирэмсний хугацаанд 6-8 удаа үзсэн хувь-61,2%
- Өртөмтгий бүлгийн жирэмсэн эхийн хяналт

2.Төрөх үеийн тусламж үйлчилгээ.

- Эх барихын тусламж үйлчилгээ –кесар хагалгааны хувь өндөр -26,5%

3.Төрсний дараахь эх, нярайн тусламж үйлчилгээ:

- Эх,нярайн эргэлт, хяналт

4.ГБТ-ийн тусламж, үйлчилгээ

16-49 насны эмгэтэйчүүдийн ГБТАХ-д хамрагдсан хувь -65,4%

# ЭМГЭГ СУДЛАЛ БА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ – ОРХОН АЙМАГ






# ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Орхон аймгийн 0-18 настай **39295** хүүхдэд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, **8** өрхийн эрүүл мэндийн төв, **1** сумын эмнэлэг, **5** хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага 15 байршилд тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

| Эмч | | Сувилагч |
|---|---|---|
| 13 | | 28 /БОЭТ/ |
| 25 | | 16 /ХХЭМБ/ |
| 51 | | 53 /СӨЭМТ/ |
| **89** | **Нийт** | **97** |

ЭМС-ын 2023 оны А/240 Хүүхэд хамгааллын журам батлах тухай тушаал

## 2023 оны хүүхдийн өвчлөлийн бүтэц






# ЭХ ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ



**5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах**

- ХӨЦМ
- ГБТ-ийн тусламж, үйлчилгээ
- ЭМБ олгох (осол гэмтлээс сэргийлэх)
- Дархлаажуулалт

**Нялхсын эндэгдлийг бууруулах**

- Гэрийн эргэлт
- ХӨЦМ
- Нярайн скрининг
- Дархлаажуулалт

**Эхийн эндэгдлийг бууруулах**

- ГБТ-ийн тусламж, үйлчилгээ
- Жирэмсний хяналт
- Хавсарсан эмгэг эмчлэх

**Нярайн эндэгдлийг бууруулах**

- Гэрийн эргэлт
- Имж эх асаргаа
- НЭҮНШТ
- Сурфактант эмчилгээ



# ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ = БҮХ НИЙТИЙН ХАМРАГДАЛТ



**Зураг 1.** Бүх нийтийн хамрагдалт (WHO, 2023)
Монгол улс – 65%

Орхон аймгийн **29,725 өрхийн** 106,231 хүн амд (+ түр болон явуулын иргэд)

**8** өрхийн эрүүл мэндийн төв, **1** сумын эмнэлэг **10** байранд **207** ажилтантайгаар тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

“Нэн шаардлагатай” тусламж үйлчилгээг хаана амьдарч байгаагаасаа үл хамааран санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байхыг хэлнэ.




## ХҮРСЭН ҮР ДҮН :

- Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292: 2017 **стандартын хэрэгжилт – 95%**
- Стандартын шаардлага хангасан барилга байгууламжтай өрхийн эмнэлэг **– 88.8%** (8/9)
- Тоног төхөөрөмжийн хангалтын хувь – **95%**
- Хүний нөөцийн хангалтын хувь- **100%**
- Тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн.

# ЭМБ-УУДЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ



## МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ЦАХИМ ПРОГРАММ - BACKEND.ACC.HDC.GOV.MN

ЭМБ-уудын **73,3%** Магадлан итгэмжлэлд хамрагдсан байна/25/

- **Анхан шатлалын 9 байгууллага -100%**
- **Ор бүхий 11 клиник- 91,6%**
- **Оргүй клиник -1 буюу 1,8%**
- 2 дахь шатлалд 4 байгууллага **100,0%**




- 1 — Бүсийн оношлогоо эмчилгээний төв-1
- 1 — Эрдэнэт медикал өрөлжсөн эмнэлэг -1
- 2 — Эрдэнэт сувилал, клиник-2
- 8 — Өрхийн эрүүл мэндийн төв-8
- 11 — Ор бүхий клиник-12
- 1 — Жаргалант сумын эрүүл мэндийн төв -1
- 1 — Оргүй клиник-53

# ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ /ДЭМБ/

- Эмнэлэгт хэвтэж байгаа 10 эмчлүүлэгч тутмын нэг нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой асуудалд өртдөг.

*50 орчим хувь нь урьдчилан сэргийлэх боломжтой*.

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой сөрөг тохиолдол, түүний хор уршиг нь нас баралт болон хөгжлийн бэрхшээлийн тэргүүлэх 10 шалтгааны нэг болж байна.

*Дунд, буурай хөгжилтэй орнуудад - 134 сая сөрөг тохиолдол бүртгэгдэж байна*.

- 10 өвчтөн тутмын 4 нь анхан шатанд болон амбулаториор үйлчлүүлэхдээ эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй тохиолдолд өртөж байна.

*Гол алдаа: оношилгоо, жор бичилт, эмийн буруу хэрэглээ*

# ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОХИОЛДОЛ БҮРТГЭЛИЙН ЦАХИМ СИСТЕМ
## /Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 дугаар тушаал/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 УЛААНБААТАР ХОТ

http://eburtgel.moh.gov.mn/




**Одоо 55 ЭМБ программ ашиглаж байна**

- Аймгийн эрүүл мэндийн газар -1
- Хувийн ортой клиник-9
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв -1
- Өрхийн эрүүл мэндийн төв-8
- Сумын эрүүл мэндийн төв-1
- Сувилал-1
- Оргүй клиник-25
- Шүдний эмнэлэг-11

| № | ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГ | Бага | Дунд | Их | Ноцтой |
|---|---|---|---|---|---|
| 1 | Халдварын сэргийлэлт, хяналттай холбоотой эрсдэл | 9 | 24 | 25 | 11 |
| 2 | Эмийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл | 3 | 22 | 19 | 4 |
| 3 | Эмчилгээ, оношилгоо, шинжилгээтэй холбоотой эрсдэл | 1 | 19 | 16 | 1 |
| 4 | Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй холбоотой эрсдэл | 6 | 24 | 18 | 6 |
| 5 | Барилга, байгууламжтай холбоотой эрсдэл | 14 | 36 | 33 | 22 |
| 6 | Ажлын байрны эрсдэл | 25 | 21 | 31 | 7 |
| 7 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл | 14 | 42 | 36 | 4 |
| 8 | Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдалтай холбоотой эрсдэл | 6 | 16 | 10 | 3 |
| 9 | Галын аюулгүй байдалтай холбоотой эрсдэл | 1 | 5 | 4 | 2 |
| 10 | Сувилахуйн тусламж үйлчилгээний эрсдэл | 2 | 7 | 5 | 6 |
| 11 | Санхүүгийн эрсдэл | | 3 | | |
| 12 | Үйл ажиллагааны эрсдэл | | 7 | 5 | 3 |

### ТОХИОЛДОЛЫН ШАЛТГААН

- Үйлчлүүлэгчийг танин тодруулгатай холбоотой — 11%
- Оношилго, эмчилгээтэй холбоотой — 45%
- Эмнэл зүйн харилцаатай холбоотой — 2%
- Эмийн аюулгүй байдал — 15%
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй халдвар — 13%
- Мэс заслын аюулгүй байдал — 2%
- Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унасан — 3%
- Цусны аюулгүй байдал — 1%
- Бусад шалтгаан — 7%

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ ХОЖИМДОЛ-ОРХОН АЙМАГ

## Хүүхдийн эндэгдлийн шалтгаан

- Хувь хүн, эцэг эхийн хараа хяналт сул, хариуцлагагүй байдал, тусламж, үйлчилгээнд оройтож хандсан хожимдол - 52,0%
- Харилцаа холбоо, дэд бүтэцтой холбоотой хожимдол 3,7%
- Хүүхдийн биеийн байдлыг дутуу үнэлсэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлээгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, хариуцлага муу, яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдаагүй 44,3%

## Хоног болоогүй нас баралтын шалтгаан

- Хувь хүн, гэр бүлийн шалтгаанаас болж, иргэн тусламж, үйлчилгээнд оройтож хандсан хожимдол 46,4%
- Харилцаа холбоо, дэд бүтэцтой холбоотой хожимдол 5,2%
- Биеийн байдлыг дутуу үнэлсэн, эрсдэлт хүчин зүйлийг тооцоолоогүй, эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлээгүй, яаралтай тусламжийн бэлэн байдал хангалтгүй, 68.0%.

# ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД НЭВТРҮҮЛСЭН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИУД



- ✓ Цус харвалт, зүрхний шигдээсийн тусламж үйлчилгээний нэгж Өндөр өртөгтэй оношилгоо – Судсан дотуурх оношилгоо
- ✓ Хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ
- ✓ Дутуу нярайн нүдний гажгийг илрүүлэх шинжилгээ
- ✓ Сурфактант эмчилгээ
- ✓ Алсын зайн оношилгоо : Зүрх судас,

- ✓ Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь RMC эмнэлэгтэй хамтарч үргүйдлийн оношилгооны кабинетыг ажиллуулж, хиймэл оюун ухааныг ашиглан умайн хүзүүний хавдрын оношилгоог 138 хүнд хийсэн
- ✓ Нейрон эмнэлэгт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна.
- ✓ Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал
- ✓ Ходоодны салст хуулах мэс засал






Тоног төхөөрөмжийн хангалт 95%

# СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ

**2023 он**

**15 асаргаа сувилагааны шинэ арга, технологи нэвтэрсэн**

- Дуслын дохиоллын аппаратыг сувилагч нар дусал тариа хийхдээ ашигласнаар санаа зоволгүйгээр өөр палатад эмчилгээ хийж байх хугацаанд дусал нь дуусвал дохио өгч дуугарах, мэдээлэл өгөх ач холбогдолтой

**200** **Сувилагчид олгосон**

**Орон нутгийн хөрөнгө оруулалтаар**

- Хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэхэд зориулсан дэрийг өндөрлөх өндөрлөгч, яаралтай тусламжийн цүнх, цус цусан бүтээгдэхүүн тээвэрлэх зөөвөрлөх цүнх, каталкны бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг хангаж иж бүрэн тоноглол,үйлчлүүлэгчийг унахаас сэргийлсэн бүс
- Хүнд ,хүндэвтэр үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэхэд /Ангио, компьютер, диалез, рентгэн, тасаг хооронд/ анхаарч 2 каталекийг хүчилтөрөгчийн баллон суурлуулж бүрэн цэнэглэж ажиллуулж байна.
- Хэвтрийн болон харвалтын дараах үлдэцтэй хөдөлгөөний дутагдалтай , хэт туранхай үйлчлүүлэгчдэд холголт цооролт үүсэх эрсдэлээс сэргийлж эвүүрүүд, ор цэвэрлэх бээлий
- Нэн хүнд болон хүнд , хөөрлийн байдалтай өвчтөнгүүд хэвтэн эмчлүүлдэг бөгөөд эдгээр эмчлүүлэгч нарт олон тооны гуурсыг биед нь байршуулсаан үед гуурсыг татах, унаж бэртэх эрсдэлтэй байдаг тул гар хөлийг оронд бэхлэх бэхэлгээ, гуурсыг татахаас сэргийлсэн бээлийвч



# СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ 25 ТУШААЛ БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙНА.

**2023 онд -2**

**Эрүүл мэндийн сайдын тушаал**

↓

**"Төлөвлөгөө батлах тухай" А/230 тоот тушаал**

↓

**"Сувилагч, эх баригч мэргэжилтний цогц чадамж" А/451 тоот тушаал**

ЭМЯ, ЭМХТ, Японы ЖАЙКА Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “**Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах**” төслийн эхний шат амжилттай хэрэгжсэн.

↓

Төслийн 2 үе шат болох **“Сувилахуйн эмнэл зүйн ур чадвар”**, “**Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр**” боловсруулах шатандаа явж байна.

# Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ




**Аймгийн хэмжээнд УАУ-ны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагууд:**

| | |
|---|---|
| УАУ-ны дагнасан ор бүхий клиник | 1 |
| УАУ-ны хавсарсан ор бүхий клиник | 11 |
| Клиник | 10 |
| **Нийт** | 22 |






| Эмч | | Сувилагч |
|---|---|---|
| 2 | БОЭТ | 1 |
| 9 | СӨЭМТ | 6 |
| 1 | ЭСЦ | 3 |
| 29 | ХХЭМБ | 12 |
| **41** | **НИЙТ** | **22** |

**Уламжлалт эм**



**Үндэсний үйлдвэрлэлийн 95 нэр төрлийн эм тана жороор олгодог**

| **Тоног төхөөрөмжийн хангалт** | **2022** | **2023** |
|---|---|---|
| **Уламжлалт анагаах ухаан** | **90.5** | **90.6** |
| **Сэргээн засах** | **75.1** | **80.2** |

# ЭМИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ




- ✓ Зайлшгүй шаардлагатай эмийн 8-р жагсаалтад эмийн санд байвал **зохих эмийн хангамж** эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 89%-тай болж, өмнөх оноос 1,6%-иар өссөн.
- ✓ Эмийн сангийн стандартын үнэлгээ дунджаар 85,7%-тай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2,5%-аар нэмэгдсэн.

# ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДЛУУД

- Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн ур чадвар, ялангуяа ургийн гажиг хөгжлийн оношилгоо, өсвөр үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж
- Хүн амын дундахь эрт илрүүлэг үзлэг оношилгооны хамрагдалт, эрүүлжүүлүүлэх хяналтад авах үйл ажиллагаа
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдлийг бүртгэх, түүнийг бууруулахтай холбоотой хариу арга хэмжээг авах, үр дүнг тооцоход байгууллагын удирдлагын багийн үүрэг оролцоо
- Эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилт, эмнэл зүйн ур чадвар, гардан үйлдлийн ур чадварыг үнэлэх
- Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байрны ачаалал, зураглал тооцох, хүний нөөцийн хангалт хүртээмж
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг, эмийн зохисгүй хэрэглээ нь эмнэлгийн тусламж үйлчилгээний хожимдолд нөлөөлдөг
- Зорилтот бүлгийн иргэдэд хүрэх тусламж үйлчилгээ : Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, хувь хүнд хариуцлага тооцох механизм

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТАВИХ САНАЛ

- Эмнэлгийн тусламж үйлчилгээн дэх эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах, хэрэгжилтийг үнэлэх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдлийг бүртгэх, бууруулахтай холбоотой хариу арга хэмжээг авах, үр дүнг тооцох
- **Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд түлхүү хүргэхэд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх**
- **Хүн амын өвчлөл, нас баралтын түвшинг бууруулах, тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих, “Сайн туршлага”-ыг түгээн дэлгэрүүлэх**
- **Мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, хангах, чадавхжуулахад чиглэсэн бодлого төлөвлөлт, зохицуулалт хийх**
- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага стандарт /MNS 7014:2023 /-ыг бүх шатлалын байгууллагууд нэвтрүүлэн үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэх
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах, аюул эрсдэлгүй тусламж үйлчилгээг үзүүлэх
- Эмийн зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх,эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавих
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эрүүл зөв амьдралын дадлын түвшинг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааг бүх шатлалын байгууллагууд тогтмол явуулах

# Анхаарал хандуулсанд баярлалаа!